

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр.

Үнэлгээний зорилго

Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт үнэлгээ хийж, хүрсэн түвшин тогтоох, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

Үнэлгээний арга зүй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ий А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ” хийх нийтлэг журмыг тус тус үндэслэн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ хийсэн.

Хяналт шинжилгээ, үнэлгээ

Төв нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний маягтын дагуу 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Шинээр төлөвлөсөн 16 арга хэмжээ
- Өмнөх оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй 10 арга хэмжээ
- Тогтмол зохион байгуулдаг 26 сарга хэмжээ багтаж байна.

1) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ

А)

| № | Байгууллага | Зорилтын тоо | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Гүйцэтгэлийн үнэлгээ | | | | | | Дундаж хувь |
|----|---------------------------------------------------------------|--------------|--------------------------|----------------------|----|----|----|----|-----|-------------|
| | | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0.0 | |
| 1. | Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 4 | 52 | 43 | 4 | 1 | | | | 98.65 |

Б)

| № | Үзүүлэлт | Жин | Гүйцэтгэлийн хувь /түвшин/ | | | | Үнэлгээний жин /түвшин/ | | | |
|---|----------------------------------------------------------------------------------------------|------|----------------------------|----------|--------|-----------|-------------------------|----------|--------|-----------|
| | | | 2022 | 2023 | | | 2022 | 2023 | | |
| | 1 | 2 | Суурь | Зорилтот | Хүрсэн | Хэрэгжилт | Суурь | Зорилтот | Хүрсэн | Хэрэгжилт |
| 1 | Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 0.20 | 95.8 | 97.6 | 98.7 | 1.58 | 19.16 | 19.52 | 19.73 | 1.02 |
| 2 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт | 0.15 | 80.0 | 90.0 | 92.9 | 1.29 | 12.00 | 13.50 | 13.93 | 1.14 |
| 3 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт | 0.30 | 85.4 | 86.0 | 94 | 14.33 | 25.62 | 25.80 | 28.20 | 1.02 |

| | | | | | | | | | | |
|-------------------------|-----------------------------------------------|-------------|------|------|----|------|--------------|--------------|--------------|-------------|
| 4 | Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт | 0.15 | 97.2 | 98.0 | 99 | 2.25 | 14.58 | 14.70 | 14.85 | 1.01 |
| 5 | Хэрэглэгчийн үнэлгээ | 0.20 | 84.0 | 85.0 | 86 | 2.00 | 16.80 | 17.00 | 17.20 | 1.01 |
| Ерөнхий үнэлгээ: | | 1.00 | | | | | 88.16 | 90.52 | 93.91 | 5.20 |

2) Хэрэгжилт сул, тайлагналтад анхаарах, засаж сайжруулах арга хэмжээ

| № | Төлөвлөгөөнд тусгагдсан заалтын дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Тайлбар |
|---|----------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 30 | Цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний заавар шинэчлэн батлуулна. | I-IV улирал | Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай ЭМС-ын 2023 оны А/177 дугаар тушаал гарч, ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн тушаалын төслийг ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Тушаал батлагдаагүй |
| 2 | 34 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. | I-IV улирал | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь оруулан тайланд тусгах |

| | | | | |
|---|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------------------------------------------------------------------------------|
| 3 | 36 | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2025)-ийн хэрэгжилтийг хангана. | I-IV улирал | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь, төлөвлөгөөнд тусгагдсан ажлаар тайлагнах |
| 4 | 38 | Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод хэрэгжүүлж, дасан зохицох хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. | I-IV улирал | Хүний нөөцийн хөдөлгөөний хувь тавьж, нөхөн хангалт хувийг бүрэн хангаагүй шаардлагагүй |
| 5 | 45 | Цусны донорын тухай хуультай уялдуулан байгууллагын дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулна. | I-IV улирал | Төвийн шинэчлэн батлуулсан бүтэц, дүрэм шалгуур үзүүлэлтийг цаашид анхаарах |

3) Дүгнэлт

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулж ЭМЯ, төрийн захиргааны удирдлагын газраас аргазүйн зөвлөгөө авч, бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж хугацаанд нь батлуулж, хэрэгжүүлж ажилласан;
2. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 70% биелэлтэй 1, 90% биелэлтэй 4 ажил, 100% биелэлтэй 47 ажил байна.
3. Хяналт шинжилгээгээ Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт 98.65 хувьтай байна.

4) Цаашид авах арга хэмжээ.

1. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн явцын хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, танилцуулгыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан зөвлөмж шийдвэрийг хэрэгжүүлэх;
2. Хэрэгжилт дутуу, дутуу тайлагнасан ажлын шалгуур үзүүлэлт, чиг үүргийн хэмжээнд шийдвэрлэх нөхцөл байдлыг анхаарч 2024 оны төлөвлөгөөнд тусгах;

3. Төлөвлөгөөний биелэлтийн тайланд тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь зорилтот түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тайлбарлах.
4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацааг анхаарч төлөвлөх.

ТАЙЛАН БИЧСЭН: ДОТООД АУДИТОР:



С.АЛТАННАМАР